

STUDIA FOLCLORICA
FOLKLORE STUDIES

<https://doi.org/10.5564/sf.v45i1.4812>

Tom. XLV

2024

fasc. 3

Алтай хайлах дэгийн онцлог

Лхаасүрэнгийн ХЭРЛЭН*
МУИС, ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын
Утга зохиол, урлаг судлалын тэнхим

Received: Jun 12, 2024

Revised: Jul 13, 2024

Accepted: Aug, 15, 2024

Хураангуй: Тууль хайлах нь үгийн, хөгжмийн, өгүүлэхүйн эрхтний шүтэлцээт, жүжгийн зэрэг нийлмэл урлаг болохынхоо хувьд гоо зүй, сэтгэл судлал, шаашин, түүхийн, угсаатны, хөгжим судлалын шинжлэх ухааны цогц судалгааны үндсэн дээр тайлбарлагдах учиртай. Тууль хөгжимт аман зохиол болохынхоо хувьд хөгжмийн онцлогийг гаргах ялангуяа аялгууны талын судалгаа хэрэгтэй байна. Дуу, хөгжим, аман зохиол тэдгээрийн угсаатны дуу хөгжимд оруулж буй арвин баялаг аялгууны онцлогийг тодруулан гаргах, аялгууны бүтэц хэлбэр өгүүлэмж, дүрслэлийг, ахуй ёс заншил, аж төрөхүйн уламжлал дунд нь судлан улмаар угсаатны хөгжмийн аялгуу дахь онцлог байдлыг хөндөх юм. Монгол Алтайн магтаал нь газар ус болон тэдний эздийг магтан дуулж баясгадаг учиртай. Алтайн магтаалд хоолойг шахаж хөнгөн зөөлөн аялгуу оруулан магтдаг бол алтайн урианхай туульд хүнд хатуу аяс оруулан хүүрнэн өгүүлэх байдлаар бэсрэг тууль хайлах хэмжээнд магтдагаараа онцлог.

Түлхүүр үг: Монгол туулийн урианхай туульчдын Алтай хайлах онцлог

Mongolian epic of Altai khailakh

KHERLEN Lkhaasuren
Department of Literature and Arts Studies, Branch of Humanity,
School of Science, NUM

Abstract: As a composite art of speech, music, narrative organ worship, and drama, epic telling should be interpreted on the basis of a complex scientific study of aesthetics, psychology, religion, history, ethnography and musicology. As it is an epic with music, it is necessary to study especially the aspect of melody to bring

out the characteristics of music. Songs, music, and oral literature will clarify the features of the rich dialects that they bring to the ethnic music, study the structure, narrative and description peculiarities of the dialect of the ethnic music. The praises of Mongolian Altai are meant to sing the praises of land and water and their owners. Altai's eulogies are sung in light and soft melodies, while Altai's hymns are sung in a heavy and hard tone.

Key words: Features of the Mongolia and Uriankhai epic

Үндсэн хэсэг

Монголын баатарлаг тууль хайлах зан үйл нь аман зохиол, хөгжим, жүжиг зэрэг олон урлагийн нэгдэл болох шинжээрээ урлагийн бусад төрлүүдээс онцгойрдог. Энэ тухай академич Ц.Дамдинсүрэн “Олонд алдартай үлгэрч, туульч нар болбоос нүүдэлчин монголчуудын үзэх жүжиг, сонсох хөгжим, унших ном гурвыг нь нэгэн зэрэг орлож, нэг жүжигчинтэй театрын үүргийг гүйцэтгэж байсан” хэмээн онцлон тэмдэглэж байжээ. Тууль хайлах зан үйл нь туульчийг урьж ирүүлэхээс эхлээд хайлах цаг, улирал, зориулалт бүхий нарийн дэг жаягтай уламжлал юм. Туульчид түүхэндээ чадамгай хуурчид, хөгжимчид, хөөмийчид, дуучид байсан байдаг. Хөг аяын нарийн мэдрэмжтэй уран бүтээлчид хэдэн зууны туршид туулийг аялгуулан хайлахдаа хөгжмийн хөг, хэмнэл, ая аялгууг хөгжмийн зэмсэгтэй хамсран шүлгийн бүтэцд тааруулан аялгуулан дуулсаар ирсэн. Тэгэхдээ энгийн бүтэцтэй мэт аялгуу хэмнэлээр туулийн утга санааг хөгжмийн найруулгатай хамсран, шинж төрхийг нь хөг аялгуугаар хайлахдаа туулийн эхлэл, өрнөл, уналт, халилт, төгсгөл зэргийг тогтвортой, тогтворгүй, хурдан удаан, хөг, хэмнэлээр сэлгэн тоочин хүүрнэдэг. Энэ нь туульч зохиолч, найруулагч, жүжигчнээс гадна, хөгжмийн зохиолч, хөгжимчин, дуучин гэсэн хөгжмийн урын санд багтах уран бүтээлч байсны гэрч юм.

Алтай хайлах дэг ёсыг эртний уламжлалаар нь өнөө цагт тээн ирсэн овог бол урианхайчууд юм. Тууль нь маш эртний үүсэл түүхтэй хийгээд хүй нэгдлийн үе, эхийн эрхт ёсны үеийн зан үйлүүдийг тусгасан байдаг тухай эрдэмтэд батлан бичсэн байна. Урианхайн түүхээс нэгэн зүйлийг тодруулбал: монголын хаа сайгүй тархсан урианхайчуудаас зөвхөн Алтайн урианхайчууд тууль хайлах соёлтой байгаа нь баатарлаг тууль хийгээд Алтай хайлах нь урианхайн уг язгуур соёл байгаагүй бөгөөд тэд Алтайд нүүж очсон цагаасаа туулийг сурч улмаар өөрийн онцлогийг шингээн одоо цагт Урианхай тууль хэмээн нэрлэгдэх болсон дэг сургуулийг бий болгожээ. Эс бөгөөс Хөвсгөл, Зүүн монгол, Төв монгол Ордост байгаа бүлэг Урианхайчуудаас баатарлаг туулийн аль нэгэн хэсэг тэмдэглэгдэн үлдэх ёстой байсан билээ. Уугуул нутаг гэж хэлж болохоор Алтайд хамгийн удаан оршин суусан овог бол урианхайчууд юм. Захчин, баяд, дөрвөд, өөлд гэх мэт баруун монголын олон ястнууд XVIII зуунаас л Алтай давж өнөөгийн нутагтаа иржээ.

Тууль хайлах үйл явц нь туулийн баатарлаг үйл явдал өгүүлэмжийн хувьд өрнөх үзэгдэл боловч ая хэмнэлийн хувьд давтах үзэгдэл юм. Тууль хайлах бүхий л хугацаанд нэг ая, нэг төрлийн аялга, товшуурын нэгэн хэвийн хэмнэл

* © Н.Хэрлэн
Email: Kherlen@num.edu.mn

давтагддаг нь орчин цагийн хотожсон соёлын үүднээс авч үзвэл дэндүү хөдөлгөөнгүй, уйтгартай мэт санагдаж болох талтай. Тухайлбал арван зургаан мянган мөр шүлэг бүхий аварга том туулийг хайлахад тэр аялгуу хэмнэл дөрвөн мянган удаа давтагдана гэсэн үг. Хүн түүнийг сонсож сэтгэл сэргэж, уран сайхны таашаалыг олж байгаа нь үнэн. Хэрэв тэр үнэн бол давталт давталт мөн ч давталт давталт биш болж таарч байна. Урлагийг хүртэх сайхны таашаал бол нэг газраа зогсох бус хөдөлгөөн хувьслын үр дүнд бий болдог сэтгэлгээний чанар юм.

Бас нэг цохож үзмээр зүйл бол тууль хайлах нь дуулах урлагтай төстэй боловч дуулах урлаг огт биш. Хэрэв дуулах урлаг байсан сан бол “тууль хайлах” гэх бус “тууль дуулах” гэсэн үг, утгаар хэрэглэгдэх ёстой болно. Туулийн үйл явдлыг өгүүлэн урсгадаг учраас бас ярих хэлэхтэй төстэй урлаг юм. Тэгвэл “тууль хэлэх” гэж томьёолох боломж бий. Энэ тухайд “тууль хайлна гэдэг нь”аргил хоолойн дом” оруулж товшуурдан хаакирч дуудах учраас тууль хэлэх гэдгээсээ ялгаатай”(Дулам, 1998: 300) гэж доктор С.Дулам тодорхойлсон байдаг. Тэгвэл “хайлна” гэдэг чухам яахын тухай дахь үйлдэл вэ? гэсэн асуудал урган гарна. Японы эрдэмтэн Камимура Акира “Алтайн Урианхай туулийн нэг онцлог нь туулийг бүдүүн дуугаар хайлдагт оршино. Үүнийг “хайлах” гэдэг. “Хайлах нь аялж дуулахаас хүчтэй бүдүүн хоолойгоор дуугардгаараа ялгаатай юм. “Хайлах” гэдэг үг Монгол хэлэнд үйл үгийн хэлбэрээр байгаа боловч “тууль хайлах ая” нь “хай” гэдэг нэр үгнээс гаралтай. Учир нь Хакасууд туулиа “хай” гэдэг бөгөөд уулын Алтайчууд туулиа “кай” гэдэг. Хакасын “хай” нь “тууль”-аас гадна “хөөмий” гэдэг утгыг багтаадаг” (Акира, 1998: 300-301) гэж тайлбар хийсэн байгаа. Энд анхаарал татаж байгаа хоёр зүйл байна. Нэгд: бүдүүн хоолойгоор аялдаг, хоёрт: “хай” гэдэг үгэнд “хөөмий” (хакас) гэсэн утга давхар байгаа талаарх ойлголт юм. Акира “хайлах” нь бүдүүн дуугаар “Алтайн эзэнтэй харилцдаг арга мөн бөгөөд ”Алтайн нуруу”-ны эргэн тойрны нутагт ер нь иймэрхүү дуугаар хүн бус юмтай харилцдаг уламжлалтай” гэсэн таамаглал дэвшүүлсэн байдаг. Тэгэхээр хайлах дуу бол Алтайн эзэнтэй харилцдаг онгодын ертөнцийн эгшиглэн байж болохоор юм. Хэрэв тийм бол олон дахин давтаж байгаа аялгуу нь ер бусын шидэт чанараараа “хүн уйдаах”-гүй байх бас нэг шинж юм.

Хайлах гэсэн ойлголтыг Оросын эрдэмтэн В.К. Шивлянова “Музыкальной исполнительская синтагма (Акира, 1998: 300-301) гэж барагцаалан тодорхойлсон байдаг. Дээрхийг товчилбол “хөгжмөн гүйцэтгэлийн хам” гэсэн шиг бууж байна. Түүнийхээр бол ярих, дуулах, хөгжимдөхийн дундаж хам шинжийг “хайлах” агуулж байна гэж ойлгож болохоор байна. Ж.Энэбиш “Ер нь дуу дуулах тууль хайлах хоёр эрс ялгаатай. Хайлах гэдэг нь хөөмийлөхтэй дүйж очно” (Энэбиш, 1998: 365) гээд “ийм учраас тууль хайлахыг дуулах аргатай адилтгах аргагүй бөгөөд туульчаас өгүүлэх эрхтний өөр үйл ажиллагаа, сэтгэл зүйн өөр бэлтгэлийг шаардана” гэж тайлбарлажээ.

Урианхайчууд Алтайн хайлах тууль хайлахдаа нэг аялгуугаар хайлдаг. Заавал товшуур хөгжимтэй хамсран төвөнхийн шахмал хоолойгоор хайлдаг нь бусад газрын туульчаас ялгаатай

Эхлэхдээ Ува-хэй хэмээн уриа дуудлагын шинжтэй аялгаар эхлэх бөгөөд энэ хэсэгтэй л Квинтийн өсрөлт хийгээд бусад бүх хэсэгтээ их Терц дотор гурван нотыг л ээлжлэн дуугарах байдлаар аялгууг зохиомжилсон байдаг. Энэ нь нэг талаар туульчийн хоолойг гамнасан байдалтай. Нөгөө талаараа сонсогчид хэдэн өдөр сараар сонсоход төвөгшөөн залхахгүй мөн аялгууны өндөр нам нэгэн жигд байх нь сонсогч хүмүүсийг аялгуунд биш харин туулийн үг, утга санаанд анхаарах, бас тайвшран бясалгах байдалд эрхгүй оруулах мэт байна. Урианхайн туульчид Алтай болон бусад туулийг нэг л аялгуугаар, зөвхөн товшуур хөгжмөөр хайлдгаараа онцлогтой.

Товшуурын хөг нь квартын хөгтэй бөгөөд бүдүүн утас нь нэг л өнгөөр дуугарах боловч нарийн утсан дээрээ тоглож байгаа нотуудтайгаа кварт, их терц, бага терцийн интервалууд үүсгэн дуугарах нь сонсоход нийцтэй төдийгүй эдгээр интервалууд нь өөрөө байгалийн өнгүүдийг төлөөлдөг учир хүн төрөлхтний хөгжмийн сэтгэлгээний эртний үеийг илэрхийлдэг билээ.

Ер нь монгол ардын язгуур урлагт ялангуяа хөөмий, цуур, тууль зэрэг хөгжмийн урлагт хөгжмийн онолын үндсэн ойлголт дахь обертоны онол хадгалагдсан байдаг нь ажиглагддаг. Энэ тухай германы хөгжмийн сайт <https://www.oberton.org/obertongesang/die-obertonreihe/> -д “Obertone нь цорын ганц байгалийн хэмжүүр учраас бүх тонал системийн үндэс суурь болдог. Ая дуугармагц хэт авианууд цуурайтах болно. Тэд бүгд нэгэн зэрэг дуугардаг. Бидний чихэнд нэг л өнгө мэт сонсогдох Overtone нь үнэндээ аккорд юм. Бүтэц нь үргэлж ижил бөгөөд математик хармоник цуваатай тохирдог. Та ихэвчлэн цуурайтаж байгаа тэр чимээг сонсдоггүй. Тэд бүгд хэт авианы хамт нэгэн зэрэг хөвч шиг чичрэн дуугардаг тул бидэнд нэг аялгуу мэт сонсогдоно. Хэт авиа гэдэг нэр нь хармоник хэсэгчилсэн хэсгүүдийг хэлнэ (хэт авиа, аялгуучилсан болон хармоникийн ялгааг доороос үзнэ үү).



Ном 1. Obertonreihe von A (110 Hz).

Obertone нь зөвхөн хөгжмийн үндэс биш бөгөөд бидний ярих, дуулах, хүмүүсийг хоолойгоор нь таних, дуу авианы байршилыг тогтоох, төгөлдөр хуурыг лимбэнээс ялгах боломжийг бас олгож байдаг. Нэг үгээр хэлбэл дуу авианы долгионы байгалийн төрлөх шинж юм. Хөгжимд илүү их шуугианыг нэмснээр хэт авиа буюу obertone шинж нь багасдаг. Гэхдээ хамгийн их харш (дисонанс) аккордууд ч хэт авиаг ямар нэг хэмжээгээр хадгалж байдаг. Учир нь тиймгүй бол бидний сонсох мэдрэхүй хүлээж авч чадахгүй шүү дээ.” гэсэн байдаг. Дээрх эгшгийн цувааг A-dur-т бичсэн бөгөөд дээрх нотуудын цувааг ля, до, фа өнгүүдээр суурилан тогловол бүгд нийцтэй сонсогдох болно. Эдгээр гурван өнгө нь дээрх нотуудын хувьд Obertone суурь нь юм. Эндээс үзвэл

товшуур хөгжмийн бүдүүн утас нь суурь болж бас тэрхүү Хэт авианы үүргийг гүйцэтгэдэг байна. Хэдийгээр сонсож байгаа хүмүүс ялган таньж чадахгүй ч туульчийн төвөнхөө шахаж дуугарч байгаа шахмал хоолойны суурь obertone нь ч товшуурын бүдүүн утаснаас гарч байгаа ноот билээ. Дээрх ишлэлд онож хэлснээр туульч товшуураа тоглон хайлж эхлэхэд л хэт авианууд цуурайтаж эхэлдэг байх нь. Ингээд бидний гурав дөрөвхөн өнгө гэж хараад байгаа өнгүүд маань хэт авиануудтайгаа холилдон зохицож найрал (хармони) аккордууд болон дуурьсдаг байна.

Туулийг энгийн хоолойгоор хайлахад ч Obertone дуугаралтаа алдахгүй. Гэхдээ урианхай туульчдын заавал шахмал хоолойгоор хайлдаг энэ урлаг нь хөөмий, шахмал хоолойн үндэс болсон Obertone дуугаралтыг нь нэмэгдүүлж илүү байгалийн хармони үүсгэн тэр хирээрээ сонсогчдод тайвшрал, бясалгалын мэдрэмжийг төрүүлдэг байх нь. Тууль хайлахын бас нэг учир нь байгаль дэлхийн эзэд, Алтайн лус савдагт зориулан хайлж байгаа учир тэрхүү өвөрмөц хоолой, ая данг сонгодог учир бий биз.

Туулийн аялгуут дууллын хэв шинжит жишээ бол эхлэл хэсэгт эрхэмсэг хүндэтгэлийн аястай “Зээ”



гэсэн нэг эгшгээс нөгөө эгшигт шилжин өргөх уриа дуудлагын аялга нь хүүхдийн аялгуут аман зохиол дахь дайралцаан, оньсого худалдах үг, 64 хул, 32 цагаан лонх, хурдан морины хүүхдийн гийнгоо, уухай, марзай зэрэгт тусгагдсан байх бөгөөд цаашлаад эрийн гурван наадмын хурдан морины цол, бөхийн цол, сурын уухай, шагайн уухай, ерөөл, магтаал, тууль, уртын дууны эхлэл хэсэгт ардын тоглоом наадам хуа, дэмбээ мөн маань мэгзэмд ч хадгалагдаж үлдсэн нь ч бий.

Энэхүү угтвар аялга нь дээрх төрөл ангилалд өөр өөрийн өвөрмөц ая аялгуу болон баяжигдан хөгжих явцдаа эгшиг хурахын хоолойн чимэг, цохилго, хөг хөглөгөө болдог хэдий ч нөгөө талаар дараагийн шүлэг ая аялгууны анхаарал төвлөрүүлэх бэлтгэл болдог. Ая аялгууны хувьд нутаг нутагт янз бүрийн аялгуугаар дуулагддаг бөгөөд энэ аялгуу нь нийтлэг дуулагддаг аялгуу юм.

Туулийн үндсэн аялгуу урт богино дууны аялгуу шиг өргөн цараатай, уран чимэглэлт аялгуутай биш хэдий ч монгол ардын дууны аялгууны хэв шинжийн зарим элементийг асгуулсан байдаг. Жишээ нь тууль хайлах явцад морин хуур, товшуур хөгжмийн үндсэн хөгт таарсан гуравц, дөрөвц, тавцын зайнд аялгуулан дуулах, эгшгийг дээш гулсуулан шидэх, доош буулгах, хөг, ая аялгууны шилжилт зэрэг нь ардын дууны аялгуутай төстэй шинжүүд ажиглагддаг. Учир нь монгол зан үйл, шашны хэлбэр, ерөөл магтаал, дууны сэдэв агуулгууд туульд өгүүлэгддэг тул тэрхүү өгүүлэмжийн ая аялгуу оролцох нь зүйн хэрэг биз.

Мөн туулийн аялгуу гол төлөв тэгш, жигд хэмнэлд хайлагддаг нь туулийн сэдэв агуулгыг сонсогч үзэгчдийн анхааралд төвлөрүүлэх, бодрол бясалгалын шинжийг уялдуулсан болов уу гэлтэй. Нөгөө талаар туульч хүн нь хөгжимчин, дуучин, хүүрнэн өгүүлэгч, бясалгагч, зохиолч зэрэг хамтын нийлмэл урлагийг зангидагч эгэлгүй авьяастан, монгол түмний сонгодог урлагийн өв тээгч, түгээгч, хадгалагч мөн билээ.

Тууль хүүрнэх явцдаа өрнөл хэсэгтээ хэмнэл нь өөрчлөгдөх, аялгууны шилжилт хөдөлгөөн солигддог бол төгсгөлдөө аялгуу, хэмнэл саарч дуусна. Эдгээрээс туулийн зохиомж, хэлбэр нь том хэмжээний хөгжмийн зохиол гэж хэлж болохоор бөгөөд үүнд зохиолын хүүрнэл, түүхэн үйл явдал, шүлэг, яруу найраг, зохиомжид задлан шинжлэл хийхээс гадна хөгжмийн ая аялгуунд нь судалгаа хийж байж гэмээ нь тууль бүхэлдээ бүтэн судлагдахуун болох болов уу (Хэрлэн, 2013: 426). Туулийг хайлах гэдэг үгээр нэрлэсэн нь уйлан хайлах, хатуу зүйл уярч зөөлөн болох гэсэн утгыг тээж байгаа хэмээн бодохуй л тэрхүү Товшуур хөгжмийн хөг хийгээд эгшгийн зохирол, туульчийн өвөрмөц шахмал хоолой нийлсэн дуурьсалаар далд ертөнцийн үзэгдэх биегүй эзэн савдаг хэмээгч энергийн урсгал, эх ундаргад хүрэх нөлөөлөх тэгснээрээ түүнийг зөөллөн уярааж хүн амьтанд ашиг тусыг үзүүлэх болно гэсэн санааг агуулж байдаг.

Урианхайчуудын туулийн сэтгэлгээ нь уламжлалт бөө мөргөлийн сэтгэлгээ дээр суурилжээ гэдэг нь харагдана. Алтай хайлах болон бусад тууль хайлах зан үйл нь ч бөөгийн зан үйлээр явж тууль хайлах аялгуу нь байгалийн цэвэр өнгүүд болон интервал, дуурьсал дээр тулгуурлан хөгжсөнөөр тайвшрал бясалгалын аялгуу шинжтэй. Урианхайн тууль хайлах дэг сургуулийн үндэс нь байгальтайгаа зохицон амьдарч, хүмүүн өөрөө байгалийн нэгэн эд эс учир түүний хуульд захирагдан орших ёстой гэсэн бөө мөргөлийн үзэл санаа байна.

Алтайн магтаалыг овоо тахилга, бөө мөргөлтэй холбон урианхайчууд хөгжүүлсэн бөгөөд Алтайн эзэн алия Хонгор, уулын эзэн Увагүнчид зэрэг бөөгийн онгод тэнгэр гэж андуурмаар дүрүүдийг бий болгож тэдний байдаг суудаг орныг тодорхойлсон байна. Алтай хайлах нь тэдгээр эзэд буюу тэнгэрийг дуудах дуудлага мэт болжээ. Алтай хайлах сонгодог гэж хэлж болохоор дэг ёс урианхайчуудын дунд хөгжин биежсэн нь чухамдаа урианхайчууд л Алтайн магтаалыг бэсрэг туулийн хэмжээнд томруулж уламжлалт шүтлэг бишрэлтэйгээ холбон зохиомжилж шинэ шинэ утга санааг нэмсэн мэт байдаг.

Дөрвөд, баяд, торгууд, захчин гэхчлэн баруун монголын бусад ястнуудын дунд “Туулийн оршил магтаал”, “Алтайн магтаал”, “Баян алтайгаа магтах”, “Алтайн уулын магтаал”, “Алтай Хангайн магтаал” гэхчлэн магтаалын хэлбэрээр оршиж байгаа нь эдгээр ястнууд урианхайчуудаас уламжлан авч хожмын явцад бөө мөргөлийг хориглосон учир шүтлэг мөргөлийн хэсгийг нь орхиж уул усны магтаал хэсгийг нь залгамжлан явжээ гэж бодогдохоор байна.

Алтай хайлах нь гүн их ёс хүндэтгэлийг шингээсэн зан үйл, шүтлэг бишрэлийн цогц хэлбэр агуулгатай бөгөөд ялангуяа ан гөрөө эрхлэн хэдэн

зуунаар хүн морь хүрэхийн аргагүй Алтайн уулын шилд оршин амьдарч ирсэн Урианхайчуудын хувьд энэ нь онцгой тод томруун шинжтэй өв уламжлалыг хадгалж ирсэн байна.

Урианхайчууд туульч болох хүн заавал удамтай байх ёстой гэх юм уу эсвэл удамт туульч л туульч болох хүүхдийг сонгон бага наснаас нь системтэй бэлдэн зааж сургадаг байна. Энэ тухай тууль судлаач урианхай овогт М.Ганболд өгүүлэхдээ. *“Дээр үед бол манай нутагт туульч болох хүүхдийг тусгай шалгуураар сонгодог байсан. Одоогийнх шиг товиуур бариад л хэн дуртай нь хайлдаг байгаагүй. Тууль сурч байгаа хүүхэд байтугай алдартай туульчид ч туулийг буруу хазгай хайлахаас их айдаг байсан байгаа юм. Тийм болохоор наанадаж энэ ёс жаягийг хатуу чанд мөрдөх хүүхдийг сонгодог байсан биз. Цаанадаж гэвэл тэр хүчирхэг тэнгэр язгуурт баатрын сүнс сүлдийг босгож ирэх гэж байгаа хүн чинь тэр туулийн баатар шигээ заяагдсан хүн байх ёстой гэсэн итгэл байсан. Ер нь бол бөөгийн тэнгэр сахиус дуудахаар заяагдсан улаач хүн шиг далд зөн совинтой хүүхдийг сонгож тодорхой сахил цээр маягийн зүйлийг туульч хүн насан туршидаа сахиж явах ёстой байдаг. Жишээ нь чөмөг ташихгүй, богино хавирга идэхгүй гэх ч юм уу.”* хэмээн өгүүлсэн билээ. Эндээс тууль нь бөө мөргөлтэй нягт холбоотой болох нь бас дахин харагдаж байна. Урианхайн туульчид удамт туульчид байдаг.

Монгол ардын баатарлаг туульд баатар хүний эрхэмлэх ёстой гурван гол чанарыг чухалчилсан байдаг. Энэ нь.

1. Зориг тэсвэр тэвчээр
2. Хайр энэрэл
3. Өстөн дайснаа үл өршөөх чанар юм. Энэ гурван чанарыг эзэмшсэн эр хүн л андгай тангараг аван төрсөн жинхэнэ эр хүн, баатар байдаг гэж монголчууд үздэг байжээ.

Өвлийн урт шөнөөр монгол хүүхдүүд тууль хайлахыг сонсож зүүрмэглэн суухдаа унтаа сэрүүний завсар энэ гурван чанар цогцолсон туулийн баатрын түүх, үйл явдал оюун ухаанд нь хоногшин, туульчийн нэгэн хэмийн аялгуунд бүүвэйлэгдэн баатар эр үзэсгэлэнт хатад мангас хортон шуламсуудын тэмцэл зөрчилдөөн ухаан, санахуйд нь далд гүн шингэдэг байжээ. Орчин үеийн хэллэгээр бол далд ухамсарт нь гүн шингэж итгэл үнэмшил болон кодлогддог байсан байна.

Хүүхдийн бага балчир оюунд хоногшсон зүйл насан туршид нь мартагддаггүй хэмээн монголчууд үздэг. Бас ямар ч албадлагагүйгээр уян яруу хайлан хоногшуулсан баатар эрийн түүх хүүхдийн далд ухамсарт шингэж тэр нь насан туршийн амьдралынх нь зам мөрийг заадаг байсан биз ээ.

Монголын нийгэмд ямар хүмүүс хэрэгтэй вэ гэвэл эрүүл чийрэг бие бялдартай, ёс суртахууны өв тэгш хөгжилтэй гэрэлтэн гялалзсан монгол хүн л хэрэгтэй. Бие бялдрын хөгжлийг уламжлалт мал аж ахуйгаас адуу малтай ноцолдон олдог харин оюун санаа, ёс суртахууны хөгжлийг баатарлаг туулиасаа аван монгол хүн, монгол баатрууд өсөн тохиоцгоодог байжээ.

Монгол хүний хүмүүжил төлөвшлийн энэ сургаал арга ухааны системийг Манжууд таслах гэж асар их хүч зүтгэл гаргасан байдаг. Тэд бөө зайрангууд, туульчдыг хоморголон алж хядан эсвэл тарчилж эрэмдэглэдэг байв.

Бас баатарлаг туулийг байн байлдаанд орохын өмнө хайлж байсан мэдээ ч бий.

Эдгээр баримтуудаас үзэхэд тууль хайлах зан үйл нь монголчуудын хувьд зугаа цэнгэлийн төдий урлаг биш, үл үзэгдэх сүнслэг оршихуйгаас ирдэг, эргүүлээд тэдгээр далд ертөнцийн эздэд зориулсан гүн хүндэтгэлтэй, итгэл бишрэлийн зан үйл болох нь тодорхой харагдана. Монголын баатарлаг тууль хайлах зан үйл нь уран зохиол үлгэр түүхийн оролцоотойгоор хүнийг баясгах зугаа цэнгэлийн хэрэгцээг хангах, түүнчлэн хатуу дэг ёс, цээр бүхий итгэл бишрэл, шүтлэг, тахилгын чанартай зан үйл болох төдийгүй монголчуудын хувьд эртнээс цэрэг дайчид, ард түмний улс төрийн оролцоог хүчтэй байлгах, тусгаар тогтнол, отог овог гэр бүлийнхээ аюулгүй байдлын төлөө амь хайргүй тэмцэх урам, эр зоригийг хөглөх оюун санааны “зэвсэг”-ийн үүргийг гүйцэтгэж байжээ.

Монголын нууц товчоо зэрэг эртний судруудад ч хүүхэд насанд хоногшсон хорсол занал, өш авах үзэл тангараг хамгийн аюултай, заавал биелдэг болохыг бишгүй өгүүлсэн нь дээрх далд ухамсрын хүчний талаар өгүүлсэн мэт байна.

Нэгэнт туульч болсон хүн насан турш тууль хайлан, ингэхдээ хорио цээрийг барьж явах ёстой бөгөөд ялангуяа туулийг буруу хайлах, засаж өөрчлөх, дутуу хайлахыг чандлан цээрлэх тангаргийг өөрийн багш болон Алтайн лус савдгуудын өмнө андгайлдаг байна.

Ийнхүү шүтлэг бишрэл, тайлга тахилгын болон үр хойчоо сурган хүмүүжүүлэх зэрэг баялаг агуулгыг туульд шингээн цогцлоож, туулийг нэгэн цогц төгс хэлбэр бүхий ертөнцийг үзэх үзэл (онол) болгон төгөлдөржүүлсэн уламжлал, дэг сургуулийг урианхайчууд бий болгосон байна.

Энэхүү дэг сургууль нь системийн шинжтэй байгаа нь мөн ажиглагдана. Тухайлбал бага наснаас нь хүүхдийг туульч болоход бэлдэх уламжлалт арга нь ямар ч албадлага хэрэглэхгүй хоногшуулан тогтоолгох аргыг зөн мэдрэмжид нь суулгаж байсан нь орчин цагийн боловсролын арга зүй гэж хэлж болохоор байгааг энд дурдууштай.

Дүгнэлт

Тууль хайлахын өмнө Алтай хайлж магтах нь баруун монголын олон ястнуудад түгээмэл хэдий ч дээр өгүүлсэн дэг сургууль гэдэг утгаар урианхайчуудын дунд Алтай хайлах нь онцгой ач холбогдолтой, заавал хийж гүйцэтгэх дэг ёс, цээрлэх цээр хориг бүхий байсан нь бусад ястнуудаас онцлог байна.

Урианхайн Алтай хайлах нь бусад ястан угсаатнаас ялгагдаж байгаа нэг гол ялгаа бөгөөд Алтайн магтаалыг бэсрэг тууль гэж үздэг. Урианхайчууд

Алтайгаар төлөөлүүлэн сав шим ертөнцийг төсөөлж, энэ ертөнцийн юм бүхэн эзэнтэй, тэрхүү эзэн савдгийг баясган магтан дуулж бас ач ивээлдээ багтаан энэрч байгаад нь баярласан талархсанаа илэрхийлж баатарлаг тууль шиг хайлж уярааж байх ёстой хэмээн үзэж Алтайг бэсрэг туулийн хэмжээнд ач холбогдол өгөн томруулж гүн хүндэтгэл шүтлэг бишрэлийн агуулгатай болгосон байна.

Ном зүй


Дулам, С. (1998). Монгол туульсын зан үйлийн шинж, түүний бэлгэдэл // *Төв Азийн тууль I симпозиумд зориулсан илтгэл*. Улаанбаатар: [Dulam, S. *Mongol tuulsoon zan üiliin shinj, tüünii belgedel*. Ulaanbaatar: 1998]

Камимура Акира. (1998). Хайлах буюу “Алтайн эзэд”-д өргөх дуу // *Төв Азийн тууль I симпозиумд зориулсан илтгэл*. Улаанбаатар:

Шивлянова, В.К. (1998). Проблема калмыцкой музыкальной традиций джангара, // *Төв Азийн тууль I симпозиумд зориулсан илтгэл*, Улаанбаатар: [Kamimura Akira. *Tuuli khailakh “Altain ezed”-d örgökh duu*. Ulaanbaatar: 1998]

Энэбиш, Ж. (1998). Тууль хайлах аргын учир // *Төв Азийн тууль I симпозиумд зориулсан илтгэл*. Улаанбаатар: [Enebish, J. *Tuuli khailakh argiin uchir*. Ulaanbaatar: 1998]

Хэрлэн, Л. (2013). Монгол тууль хөгжмийн урлагийн нэгэн судлагдахуун мөн // *Төв Азийн тууль-2, ЭШБ* [Kherlen, L. *Mongol tuuli khögjmiin urlagiin negen sudlagdakhuiin mön*. Ulaanbaatar: 2013]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate

credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.

ДОМОГ, ҮЛГЭРИЙН СУДАЛГАА